



МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөрийн урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
2. Уламжлалт анагаахын эмнэлзүйн тохиолдолд суурилсан уламжлалт амирлуулах /тан, талх, үрэл, ханд, архин, тосон, зуурマル, үнсэн/ эмийн сонголт, хослуулан хэрэглэсэн туршлага, үр дүнгийн тайлан /холбогдох материалыг хавсаргах/;
3. Зонхилон тохиолдох өвчиний үеийн хануур заслаас өргөн хэрэглэдэг 10 доошгүй судсыг ханах чадвартай байх /тайлан, бичлэг, CD ирүүлэх/;
4. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх;

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Уламжлалт анагаах ухаан судлалаар төрөлжиж, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байх;
2. УАУ-ны идээ ундаа, явдал мөрийн урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг бус нутагт зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
3. Уламжлалт анагаах ухааны эмнэлзүйн тохиолдлын үеийн уламжлалт амирлуулах, арилгах эмийн эмчилгээг хийдэг байх /холбогдох материалыг хавсаргах/;
4. Уламжлалт анагаах ухааны ширүүн заслуудаас хануур, хаттуур зэрэг өндөр үр чадвар шаардах заслуудыг хийх чадвартай байх /тайлан, CD ирүүлэх/
5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, бүтээл хэлэлцүүлж, анагаах ухааны мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл, хэвлэлд нийтлүүлсэн байх;

6. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх;

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Удирдахуйн болон мэргэшлийн чиглэлээр эмнэлзүйн сургагч багш болсон байх;
2. Уламжлалт анагаах ухааны идээ ундаа, явдал мөрийн урьдчилан сэргийлэх аргын тухай нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцсон байх;
3. Уламжлалт анагаах ухааны төрөлжсөн мэргэшлийг чадамгай эзэмшиж, Уламжлалт анагаах ухааны 4 өрөндгөөр амжилттай эмчилсэн туршлага, үр дүн, тайлан;
4. Зонхиолон тохиолдох өвчин, түүний хүндрэл, ховор тохиолдох эмгэгийн үеийн Уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний чиглэлээр эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний бүх шатлалын эмнэлэгт зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай байх;
5. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гардан хийж 5 –аас доошгүй бүтээл хэвлүүлж үүний 2 нь олон улсын хуралд илтгэгдэж, мэргэжлийн хэвлэлд нийтлэгдсэн байх;
6. Сургалт эрхлэгч байгууллагаас /мэргэжлийн нийгэмлэг, холбоо/ зохион байгуулсан багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдан багц цагийн бүрдүүлэлтийн 50%-ийг бүрдүүлсэн байх.